



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Г Т
Маягт, нөхөх заавар, журам батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.10 дахь хэсэг, Үндэсний статистикийн хорооны даргын А/143 дугаар тушаал, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын зохион байгуулах, хянан зохицуулах Үндэсний зөвлөлийн чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайлангийн маягт ОҮИТБС-1, ОҮИТБС-2, ОҮИТБС-3, ОҮИТБС-4, ОҮИТБС-5, ОҮИТБС-6, нөхөх заавар”-ын загварыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Маягт, нөхөх заавар, журам батлах тухай” Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 1/3/1 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайлангийн маягт ОҮИТБС-1, ОҮИТБС-2, ОҮИТБС-3, ОҮИТБС-4, ОҮИТБС-5, ОҮИТБС-6 болон нөхөх заавар”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

Гурав. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Х.Ганцогт/-д үүрэг болгосугай

САЙД

Б. БОЛОР



000114